



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.03.28 № СЭ-112-12/1422
танай _____-ны № _____-т

ХӨНГӨН ЦАГААНЫ ХАЙЛШ
НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРТ
ОРОЛЦОГЧДОД

Гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдлийг
түр хугацаагаар түдгэлзүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Төмөрт хром /200/” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240202032 дугаартай тендер шалгаруулалтад оролцсон “Ай Ти ворлд центр” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсэг, Сангийн яамны 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан тул Сангийн яамны 2024 оны 03 дугаар сарын 27 өдрийн 03/1959 дүгээр албан бичгээр гүйцэтгэгч сонгох ажиллагааг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар түдгэлзүүлсэн болохыг мэдэгдье.

Тус тендер шалгаруулалтын тендер хүчинтэй байх хугацааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт заасны дагуу ажлын 15 хоногийн хугацаагаар сунгаж байгааг мэдэгдье.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ

612407007082



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН
ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024. 03. 27 № 03/1959
танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтыг түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан ЭҮТӨҮГ/20240102032 дугаартай “Төмөрт хром /200/” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Ай Ти ворлд центр” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
3. Батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичиг;
4. Оролцогчдын ирүүлсэн тендер /Тендер нээх нууц үг/;
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
6. Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
7. Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
8. Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
9. Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
10. Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу бусад оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэх, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байхыг үүгээр мэдэгдэж байна.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

9766003335